



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/187

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 188 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ГААОНӨГ/202312019 дугаартай Алтай хотын Жанчивын гудамжны тохижилт, шинэчлэлтийн ажлыг Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 6-1/6076 дугаар зөвлөмжийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Есөнбулаг Засаг дарга (А.Алтанхуяг)-д олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Есөнбулаг Засаг дарга (А.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (С.Амгалан), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ